

СУРАГЧИЙН БҮРТГЭЛД ШААРДЛАГАТАЙ БИЧИГ БАРИМТУУДЫН ЖАГСААЛТ**АРЛИНГТОНЫ УЛСЫН СУРГУУЛЬД БҮРТГҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ БИЧИГ БАРИМТУУД:****1. Хүүхдийн нас, нэр тодорхойлох**

- ☐ Төрсний Гэрчилгээний Эх хувь – Төрсний гэрчилгээ Англи хэлээр биш бол албан ёсны орчуулга шаардлагатай.

2. Оршин суух хаяг тодорхойлох

Эцэг эх юмуу шүүхээс томилогдсон асран хамгаалагч нь хүүхдийн хамт Арлингтоны оршин суугч гэдгийг нотлох.

Орон сууц эзэмшигч юм уу түрээслэгчийн бүрдүүлэх бичиг баримт

Хүүхдийн эцэг эх/ асран хамгаалагч нь орон сууц эзэмшигч, эсвэл түрээслэгч бол дараах ГУРВАН (3) баримт шаардлагатай:

Дараахийн аль НЭГ (1) үндсэн бичиг баримт:

- ☐ Эцэг эх/хууль ёсны асран хамгаалагч нь Арлингтонд орон сууц эзэмшиж, оршин суудаг болохыг нотлох Deed¹.
☐ Эцэг эх/хууль ёсны асран хамгаалагчийн нэр дээрх түрээслүүлэгч болон түрээслэгчийн гарын үсэг бүхий Lease Agreement².
☐ Settlement Documentation³ - Шинэ тутам орон сууц худалдаж авсан бөгөөд Deed хараахан гараагүй бол

МӨН

Гэрийн хаяг болон эцэг эх/хууль ёсны асран хамгаалагчийн нэр бүхий хоёр (2) бичиг баримтыг дараах жагсаалтаас:

Тухайн жилийн Холбооны, мужийн эсвэл хөрөнгийн татварын тайлан, сүүлийн цалингийн тайлан, Тээврийн хэрэгслийн бүртгэл, Хэрэглээний төлбөрийн нэхэмжлэл (хий, цахилгаан, ус г.м), одоогийн хаягтай Виржина мужийн жолооны үнэмлэх эсвэл бусад төрийн байгууллагаас олгосон зурагтай үнэмлэх, Арлингтон хотоос олгодог халамжийн тэтгэмжтэй холбоотой баримт, сүүлийн банкны дансны тайлан, гэрийн хаяг бүхий орон сууцны юм уу түрээслэгчийн хариуцлагын даатгалын гэрээ, сонгогчийн үнэмлэх, татварын 1099 юм уу W-2 маягт зэрэг болно.

Өөр айлд амьдарч буй гэр бүлийн бүрдүүлэх бичиг баримтууд

Өөр айлын гэрт хүүхдийн хамт амьдарч буй гэр бүлүүд дараах жагсаалтаас ТАВАН (5) бичиг баримт бүрдүүлнэ.

Дараах жагсаалтад буй гурван (3) бичиг баримтууд бүгд шаардлагатай:

- ☐ Form A - Parent/Legal Guardian/Adult Student Residency Affidavit.⁴
☐ Form B- Statement of Arlington Resident Affidavit.⁵
☐ Deed эсвэл Lease Agreement эсвэл Settlement Documentation (Шинэ тутам орон сууц худалдаж авсан бөгөөд Deed хараахан гараагүй бол)

МӨН

Гэрийн хаяг болон эцэг эх/хууль ёсны асран хамгаалагчийн нэр бүхий хоёр (2) бичиг баримтыг дараах жагсаалтаас:

Тухайн жилийн Холбооны, мужийн эсвэл хөрөнгийн татварын тайлан, сүүлийн цалингийн тайлан, Тээврийн хэрэгслийн бүртгэл, Хэрэглээний төлбөрийн нэхэмжлэл (хий, цахилгаан, ус г.м), одоогийн хаягтай Виржина мужийн жолооны үнэмлэх эсвэл бусад төрийн байгууллагаас олгосон зурагтай үнэмлэх, Арлингтон хотоос олгодог халамжийн тэтгэмжтэй холбоотой баримт, сүүлийн банкны дансны тайлан, гэрийн хаяг бүхий орон сууцны юм уу түрээслэгчийн хариуцлагын даатгалын гэрээ, сонгогчийн үнэмлэх, татварын 1099 юм уу W-2 маягт зэрэг болно.

Form A болон Form B маягтуудыг дараах хаягаас татаж авна уу: <https://www.apsva.us/registration/required-documents/>

3. Хүүхдийн эцэг эхийн нэр болон хамаарлыг тодорхойлох

Эцэг эх/шүүхээс томилогдсон асран хамгаалагчийн төрийн байгууллагаас олгосон хүчинтэй зураг бүхий үнэмлэх шаардлагатай.

Дараахийн аль нэг биеийн байцаалт:

- ☐ Төрийн байгууллагаас олгосон зураг бүхий үнэмлэх ☐ Жолооны Үнэмлэх ☐ Паспорт

АРЛИНГТОНЫ УЛСЫН СУРГУУЛЬ БҮРТГҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ МАЯГТУУД

- ☐ Student Registration Form- PreK-12-р ангиудад шинээр болон дахин бүртгүүлж буй бүх сурагчдын бөглөх Бүртгэлийн Маягт
☐ Pre-Kindergarten Experience- Kindergarten ангид шинээр элсэн орж буй бүх сурагчид бөглөнө.

ЭРҮҮЛ МЭНДИЙН БИЧИГ БАРИМТУУД

Хэдийгээр анх бүртгүүлэхэд заавал шаардлагагүй ч сурагчид хичээлд суухын тулд дараах бичиг баримтуудыг заавал бүрдүүлнэ: Дархаажуулалт (Pre-K- 12-р ангийн сурагчид), сургуульд орохоос өмнөх 12 сарын дотор хийсэн сүрьеэгийн сорил (Pre-K- 12-р ангийн сурагчид), сургуульд орохоос өмнөх 12 сарын дотор хийсэн ерөнхий эрүүл мэндийн үзлэг (Pre-K- 5-р ангийн сурагчид).

СУРГУУЛИЙН БИЧИГ БАРИМТ, ДҮНГИЙН ХУУЛБАР

Бүртгэл хийхэд заавал шаардахгүй ч өмнө нь сурч байсан сургуулийн хувийн хэрэг, дүнгийн хуулбар зэргийг авч ирнэ үү. Мөн тусгай боловсролын Individualized Education Program (IEP), 504 Plan, Англи хэл суралцагчийн үйлчилгээ болон Гоц авъяастны (Gifted) үйлчилгээ зэрэгтэй холбоотой бичиг баримтууд байгаа бол авч ирнэ үү.

Бүртгэлийн бүх маягтуудыг даарах хаягаас татаж авна уу: <https://www.apsva.us/registration/>

¹ Deed – Орон сууц эзэмшигчийн үл хөдлөх хөрөнгө худалдан авсан гэрээ; Үл хөдлөх хөрөнгийн Гэрчилгээтэй дүйх бичиг баримт. Цаашид “Deed” гэх

² Lease Agreement – Орон сууц, үл хөдлөх хөрөнгө түрээслэх Түрээсийн Гэрээ. Цаашид “Lease Agreement” гэх

³ Settlement Documentation- Үл хөдлөх хөрөнгө худалдаж авах моргэжийн зээлийн гэрээ.

⁴ Form A – Сурагчийн эцэг эх нь Арлингтоны хаяг дээр айлын гэрт амьдарч буйг нотлох хувийн баталгаа

⁵ Form B – Арлингтоны оршин суугч нь тухайн хүний хаяг дээр хүүхэд эцэг эхийн хамт амьдарч буйг нотлох хувийн баталгаа.